



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны “Зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай” 385 дугаар тогтоолыг тус үндэслэн ТОГТООХ нь:

1.”Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн албан хэрэгцээнд зориулан, байгууллагын өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 120,000,000.00 (нэг зуун хорин сая) төгрөгт багтаан автомашин авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникин үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.

2.Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн дарга Ж.Батсуурь нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 01 дугээр сарын ~~1~~-ны өдрийн  
...~~43~~..... дугаар тогтоолын хавсралт

"Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах  
зөвлөл"-ийн худалдан авах автомашины техникийн үзүүлэлт,  
үнийн дээд хязгаар

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Худалдан авах үнийн дээд хязгаар
				(төгрөг)
1	Суудлын тоо 8, хөдөлгүүрийн багтаамж 4700 cc хүртэл (улсын дугаар аваагүй)	ш	1	120,000,000.00
<b>Нийт дүн</b>			<b>1</b>	<b>120,000,000.00</b> <b>(нэг зуун хорин сая)</b>